



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/228

Хэрлэн сум

Төсөл арга хэмжээний худалдан
авах ажиллагаа зохион байгуулах тухай

“Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дүгээр зүйлийн 60.1.21, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 10.5, 10.6 дахь хэсэг, Монгол “Улсын 2024 оны төсвийн тухай” хуулийн 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн 2024 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээр батлагдсан Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл (Хэнтий) төсөл, арга хэмжээг 2 багцад хуваарилан худалдан авах ажиллагааг зохион байгуулсугай.


2.Худалдан авах ажиллагааны багцын төсөвт өртөг, санхүүжих дүнг хавсралтаар баталсугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны
... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар захирамжийн хавсралт

**ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
БАГЦЫН ТӨСӨВТ ӨРТӨГ, САНХҮҮЖИХ ДҮН**

Багцын дугаар	Багцын нэр	Төсөвт өртөг (сая төгрөг)	2024 оны санхүүжилт (сая төгрөг)
Багц 1	"Шинэ хөдөө" төсөл Багц.1 /машин тоног төхөөрөмж/	1,155.0	1,155.0
Багц 2	"Шинэ хөдөө" төсөл Багц.2 /тариалангийн тоног төхөөрөмж/	759.5	759.5
Нийт		1,914.5	1,914.5